



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**



**ХАРИЛЦАА ХОЛБОО
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ХӨГЖЛИЙН ХҮСЛЭН ХОЛБОО**

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХАНДЛАГА ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

2024 он

АГУУЛГА

ГРАФИКУУДЫН ЖАГСААЛТ	0
ОРШИЛ	1
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АСУУЛТ	2
Судалгааны зорилго	2
Судалгааны асуултууд	2
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	4
1. Судалгааны хамрах хүрээ	4
2. Судалгааны арга	5
3. Түүвэрлэлт	5
4. Мэдээлэл цуглуулалт	5
5. Мэдээллийн шинжилгээ	6
6. Ёс зүйн асуудлууд	6
СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ	7
АСРАН ХАМГААЛАГЧ	10
ХҮҮХЭД	20
БАГШ	28
СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ	33
1. Судалгааны үр дүнгийн дүгнэлт	33
2. Зөвлөмж	34
ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН СУДАЛГААНЫ САНАЛ	36
1. Дүгнэлт	36
2. Цаашдын судалгааны санал	36
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	38

ГРАФИКУУДЫН ЖАГСААЛТ

График 1. Хүйс болон оршин суудаг дүүрэг	8
График 2. Өрхийн орлого	9
График 3. Асран хамгаалагчдын насны бүлэг	11
График 4. Асран хамгаалагчдын цахим орчинд хандах давтамж	12
График 5. Асран хамгаалагчийн ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх .	12
График 6. Асран хамгаалагчдын хэрэглэдэг платформ.....	13
График 7. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ.....	14
График 8. Асран хамгаалагчид цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх	14
График 9. Асран хамгаалагчдад их давтамжтай харагдсан насанд хүрэгчдийн контент	15
График 10. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх.....	16
График 11. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контент үзсэнээр гарч болох сөрөг нөлөө.....	17
График 12. Хүүхдийг насанд хүрэгчдэд зориулсан контентээс хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ	18
График 13. Хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай гэж та үзэж байгаа эсэх	19
График 14. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн насны бүлэг	20
График 15. Хүүхдүүдийн цахим орчинд ханддаг давтамж	21
График 16. Хүүхдүүдийн ашигладаг платформ.....	22
График 17. Хүүхдүүдийн цахим орчинд үздэг контентийн төрөл.....	22
График 18. Та нийгмийн сүлжээн дээр насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан уу?	23
График 19. Хүүхдүүдийн цахим орчинд харж байсан насанд хүрэгчдийн контент	24
График 20. Хүүхдүүд насанд хүрэгчдэд зориулсан контент хараад хийдэг үйлдэл	25
График 21. Хүүхдүүдэд насанд хүрэгчдийн контент хараад төрдөг сэтгэгдэл	26
График 22. Хүүхэд өөрийгөө цахим орчинд аюулгүй гэж боддог эсэх	27
График 23. Багш нарын насны бүлэг.....	28
График 24. Багш нарын цахим орчинд хандах давтамж	29
График 25. Багш нарын ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх	29
График 26. Багш нарын хэрэглэдэг платформ.....	30
График 27. Багш нарын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ	31
График 28. Багш нар цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх	31
График 29. Багш нарын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх	32
График 30. Багш нарын бодлоор хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай юу?	32

ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь хүмүүсийн амьдралд томоохон нөлөө үзүүлж, цахим орчин өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болоод байна. Интернет, нийгмийн сүлжээ, болон бусад цахим хэрэгслүүд нь хүмүүсийн харилцаа холбоо, мэдээлэл солилцоо, боловсрол болон ажил эрхлэлтийн арга хэлбэрийг өөрчилж, өргөн боломж олгож буй ч, үүний зэрэгцээ олон төрлийн аюул, эрсдэлийг дагуулсаар байна.

Монгол Улсад цахим орчны хэрэглээний хүрээ хурдацтай тэлж, өсвөр насныхан болон насанд хүрэгчдийн дунд интернэтийн хэрэглээ нийтлэг үзэгдэл болжээ. Гэвч цахим орчны ашиглалтаас үүдэлтэй эрсдэлүүд, тухайлбал, сөрөг контент, кибер дээрэлхэлт, мэдээллийн аюулгүй байдлын асуудал улам бүр хурцаар тавигдаж байна. Эдгээр эрсдэлүүд нь ялангуяа хүүхдүүдэд илүү хүчтэй нөлөөлдөг бөгөөд тэдний аюулгүй байдал, сэтгэл санааны байдалд хохирол учруулж болзошгүй юм.

Судалгааны үндэслэл: Монгол Улсад цахим орчны хэрэглээний соёл, насанд хүрэгчдийн үүрэг хариуцлага төдийлөн хангалттай хөгжөөгүй байгаа өнөөгийн нөхцөлд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд судалгааны үр дүн дээр тулгуурлан бодлого, арга хэмжээг тодорхойлох шаардлага гарч байна. Насанд хүрэгчид цахим орчны хяналт, зөв зохицуулалтыг хангахгүй байх нь хүүхдүүдийг цахим орчинд аюулд өртөх нөхцөлд хүргэж байгаа учраас энэ асуудлыг шийдвэрлэх нь нэн тэргүүний зорилт юм.

Судалгааны ач холбогдол: Энэ судалгаа нь цахим орчин дахь насанд хүрэгчдийн хандлага хүүхдийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг шинжлэхэд чиглэгдэнэ. Судалгааны үр дүн нь нийгэмд цахим орчны хэрэглээний талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, бодлого боловсруулагчид, эцэг эхчүүд болон багш нарт хэрэгтэй зөвлөмж гаргахад үнэтэй хувь нэмэр оруулна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО БА АСУУЛТ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь цахим орчин дахь насанд хүрэгчдийн хандлага хүүхдийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг судалж, түүнээс улбаалан үүсэж болох эрсдэлийг бууруулах, цахим орчны зохистой хэрэглээг бий болгоход чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Үндсэн зорилтууд:

1. Цахим орчны хэрэглээний өнөөгийн нөхцөл байдлыг насанд хүрэгчид болон хүүхдүүдийн хувьд тодорхойлох.
2. Насанд хүрэгчдийн хандлага, цахим орчныг ашиглах арга барил, дадал зуршлуудыг судлах.
3. Хүүхдийн цахим орчны хэрэглээнд насанд хүрэгчдийн зүгээс үзүүлж буй хяналт, зохицуулалтын үр нөлөөг үнэлэх.
4. Хүүхдүүдэд учирч буй цахим орчны эрсдэлүүдийг тодорхойлох.
5. Судалгааны үр дүнд үндэслэн хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлогын зөвлөмж гаргах.

СУДАЛГААНЫ АСУУЛТУУД

Судалгааны гол асуултуудыг дараах байдлаар тодорхойлж байна:

1. Насанд хүрэгчид цахим орчныг хэрхэн ашиглаж байна вэ?
 - Интернэт болон нийгмийн сүлжээнд хандах давтамж.
2. Хүүхдүүд цахим орчныг ашиглахдаа ямар төрлийн аюул, эрсдэлүүдтэй тулгардаг вэ?
 - Сөрөг контент, кибер дээрэлхэлт, хууль бус үйлдэлд өртөх магадлал.
 - Хүүхдүүдийн цахим орчны мэдлэг, өөрийгөө хамгаалах чадвар.
3. Насанд хүрэгчдийн цахим орчны хандлагаас хүүхдийн аюулгүй байдалд ямар нөлөө үзүүлдэг вэ?
 - Эцэг эх, багш нарын хяналт, заавар зөвлөгөөний үр нөлөө.
 - Насанд хүрэгчдийн хариуцлагагүй хандлагын сөрөг үр дагавар.

4. Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангахад ямар арга хэмжээ, бодлого шаардлагатай вэ?

- Эцэг эхчүүдийн сургалт, мэдээллийн тэгш байдал.
- Боловсролын байгууллагуудын үүрэг, төрийн бодлого.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны ажил нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, тэдний асран хамгаалагчид болон багш нарын төлөөллийг хамруулан гүйцэтгэгдсэн. Үүнд:

- **Сурагчид:** 13-19 насны хүүхдүүд. Монгол улсад 2023 оны байдлаар 10-19 насны нийт 612,721 хүн байна (ҮСХ, 2024). Нийт 10-19 насны хүмүүсээс 95 хувийн итгэх завсарт 384 хүнээс судалгаа авахад нийт хүн амыг төлөөлж чадна гэж авч үзсэн. Судалгаанд 13-19 насны нийт **405** хүүхэд оролцсон болно.
- **Асран хамгаалагчид:** 13-19 насны хүүхдүүдийн асран хамгаалагчид. Монгол улсад 2023 оны байдлаар 20-с дээш насны нийт 2,144,686 хүн байна (ҮСХ, Хүн ам, 2024) Нийт 20-с дээш насны хүмүүсээс 95 хувийн итгэх завсарт 385 хүнээс судалгаа авахад нийт хүн амыг төлөөлж чадна гэж авч үзсэн. Судалгаанд 20-с дээш насны нийт **462** 13-19 настай хүүхдүүдийн асран хамгаалагчид оролцсон болно.
- **Багш нар:** 13-19 насны хүүхдүүдэд хичээл заадаг багш нар. Монгол улсад 2023 оны байдлаар нийт 54,189 багш нар байна. (ҮСХ, Боловсрол, соёл шинжлэх ухаан, 2024) Нийт багш нараас 90 хувийн итгэх завсарт 139 багшаас судалгаа авахад нийт багш нарыг төлөөлж чадна гэж үзсэн. Судалгаанд нийт **152** багш оролцсон байна.

Судалгаанд нийтдээ 1019 хүн хамрагдсан бөгөөд үүний 39.7% нь хүүхдүүд, 45.3% нь асран хамгаалагчид, үлдсэн 15% нь багш нар байв. Нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 20% нь цаасаар, үлдсэн 80% нь онлайнаар судалгаанд оролцсон бөгөөд цаасан анкет бөглөсөн хүмүүсийн хариултыг онлайн асуулгад гараар оруулсан тул нийт үр дүнг онлайнаар харах боломжтой.

2. СУДАЛГААНЫ АРГА

Санал асуулгын арга

Судалгаанд санал асуулгын арга ашигласан бөгөөд үүнд:

- **Тоон болон чанарын судалгаа:** Тоон болон чанарын мэдээлэл цуглуулах зорилгоор статистикийн тоон асуултууд болон чанарын мэдээллийг цуглуулах анкет боловсруулав. Энэ нь цахим орчны хэрэглээ, хандлага, аюулгүй байдлын талаар дүн шинжилгээ хийхэд зориулагдсан.

Асуулгын бүтэц

Санал асуулгын хуудас нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

1. Оролцогчийн үндсэн мэдээлэл (нас, хүйс, боловсролын түвшин).
2. Цахим орчны хэрэглээний хандлага (хэрэглэх давтамж).
3. Хүүхдүүдийн аюулгүй байдалд учирч буй эрсдэлүүдийн талаархи ойлголт.
4. Насанд хүрэгчдийн хяналт, оролцоо.
5. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдийн талаарх санал.

3. ТҮҮВЭРЛЭЛТ

Түүвэрлэлт нь судалгааны зорилгод нийцүүлэн олон төрлийн бүлгүүдийг хамруулах байдлаар хийгдсэн. Судалгаанд оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгож, нас, хүйс, боловсролын түвшний хувьд тэнцвэртэй байхаар зохицуулсан.

4. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Мэдээллийг дараах хэлбэрээр цуглуулсан:

- **Онлайн анкет:** Цахим орчинд Google Forms ашиглан оролцогчдоос асуулга авсан.
- **Цаасан анкет:** Гадуур явж хүмүүсээс судалгаанд оролцох боломжтой 13-19 насны хүүхдүүд, тэдний асран хамгаалагчид болон багш нараас цаасан байдлаар асуулга авсан.

5. МЭДЭЭЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Цуглуулсан мэдээллийг дараах аргуудыг ашиглан боловсруулсан:

- **Тоон шинжилгээ:** Статистикийн дүн шинжилгээ хийж, насанд хүрэгчдийн цахим орчны хандлагыг хүүхдийн аюулгүй байдалд үзүүлж буй нөлөөлөлтэй харьцуулсан.
- **Чанарын шинжилгээ:** Асуулга дээр буй чанарын мэдээлэлд шинжилгээ хийсэн болно.

6. ЁС ЗҮЙН АСУУДЛУУД

Судалгаанд оролцогчдын мэдээллийн нууцлалыг бүрэн хангаж, зөвшөөрөл авсны үндсэн дээр мэдээлэл цуглуулсан. Хүүхдүүдтэй холбоотой мэдээллийг эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр авсан болно.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Нийт судалгаанд 1019 хүн оролцсон бөгөөд тэдний хүйс болон оршин суудаг дүүргийн хамаарлыг доорх графикт харуулав. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү их хувиар судалгаанд хамрагдсан бөгөөд оршин суудаг дүүргийн хувьд жигд тархалттай байна.

- **Дүүрэг тус бүрт эмэгтэй, эрэгтэй оролцогчдын харьцаа:**

- Графикаас харахад **Баянзүрх дүүрэгт** хамгийн олон оролцогч (10.3%) байжээ. Үүнээс эмэгтэй оролцогчид илүү өндөр хувийг эзэлж байна.
- **Сонгинохайрхан дүүрэг** дараагаар орж, оролцогчдын 8.83% нь тус дүүргээс ирсэн бөгөөд мөн эмэгтэй оролцогчид давамгайлж байна.
- **Хан-Уул (7.75%)** болон **Баянгол (6.87%)** дүүргүүд мөн өндөр хувиар оролцжээ.
- Хамгийн бага хувийн оролцоо **Чингэлтэй дүүрэгт** байсан (3.93%), хүйсийн хувьд эрэгтэй оролцогчид бага зэрэг давамгайлж байна.

- **Эмэгтэй, эрэгтэй оролцогчдын ерөнхий хандлага:**

- Бүх дүүргүүдэд эмэгтэй оролцогчдын хувь эрэгтэйчүүдээс илүү давамгайлж байгаа нь ажиглагдаж байна.
- Эрэгтэйчүүдийн хувьд оролцоо **Баянзүрх (5.59%)** болон **Хан-Уул (4.91%)** дүүргүүдэд арай өндөр байна.


- **Хамгийн том ялгаа:**

- Эмэгтэй, эрэгтэй оролцогчдын хоорондын хамгийн том хувийн зөрүү **Сонгинохайрхан дүүрэгт** (8.83% эмэгтэй, 4.12% эрэгтэй) ажиглагдаж байна.

- **Тэнцвэртэй байдал:**

- **Багануур** болон **Налайх** дүүргүүдэд эмэгтэй, эрэгтэй оролцогчдын хувь тэнцвэртэй байдалтай байна. Жишээлбэл, Багануур дүүрэгт эмэгтэй (4.12%), эрэгтэй (4.71%) хувийн ялгаа маш бага байна.

График 1. Хүйс болон оршин суудаг дүүрэг



Нийт судалгаанд оролцогчдын өрхийн орлого нь ерөнхийдөө нийгмийн давхрагын пирамидай төстэй хэлбэртэй байгаа нь түүврүүд нийт монгол улсын хүн амыг төлөөлж чадахаар байна.

• **Дундаж орлоготой өрх (57.5%):**

- Судалгаанд оролцсон өрхүүдийн дийлэнх буюу 57.5% нь дундаж орлоготой өрхөд хамаарч байна.
- Энэ нь тухайн оролцогчдын дундаж амьжиргааны түвшинг харуулж байгаагийн зэрэгцээ судалгаанд оролцогчдын дийлэнх нь эдийн засгийн хувьд тогтвортой, боломжийн орлоготой хүмүүс байсныг илтгэж байна.


• **Бага орлоготой өрх (23.3%):**

- Судалгаанд хамрагдсан өрхийн 23.3% нь бага орлоготой бүлэгт хамаарсан байна.
- Энэ нь тухайн өрхүүдийн санхүүгийн боломж хязгаарлагдмал, зарим үндсэн хэрэгцээгээ хангахад хүндрэлтэй байгааг илтгэх магадлалтай.

- **Өндөр орлоготой өрх (19.2%):**

- Судалгаанд оролцогчдын 19.2% нь өндөр орлоготой өрхөд багтаж байгаа нь харьцангуй цөөн байгаа ч нийгэмд эдийн засгийн хувьд илүү амжилттай амьдралтай хэсгийг төлөөлж байна.

График 2. Өрхийн орлого



АСРАН ХАМГААЛАГЧ

Доорх графикт 13-19 насны хүүхдүүдийн асран хамгаалагчдын насны бүлгийг харуулав. Оролцогчдын насны бүлгийг тэнцвэртэй хадгалахыг зорьсон бөгөөд ингэснээр судалгааны үр дүнд илүү итгэлтэй байх болно.

- **18-24 насны бүлэг (12.2%):**

- Харьцангуй залуу буюу 18-24 насны бүлэг нийт оролцогчдын 12.2%-ийг эзэлж байна.
- Энэ нь судалгаанд оролцогч залуусын хувь харьцангуй бага байгааг илтгэж байна.

- **25-34 насны бүлэг (29.8%):**

- Судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 29.8% нь 25-34 насны ангилалд хамаарч байна.
- Энэ бүлэг нь идэвхтэй хөдөлмөрийн насныхан, нийгмийн идэвхтэй оролцоотой хэсгийг илэрхийлж байж магадгүй.

- **35-44 насны бүлэг (24.7%):**

- Судалгаанд оролцогчдын хоёр дахь том бүлэг бол 35-44 насныхан бөгөөд нийт оролцогчдын 24.7%-ийг эзэлж байна.
- Энэ бүлэг нь мөн эдийн засгийн гол хөдөлгүүр болох насны бүлэг гэж үзэж болох юм.

- **45-54 насны бүлэг (13.6%):**

- 45-54 насны бүлэг нийт оролцогчдын 13.6%-ийг бүрдүүлж байна.
- Энэ бүлэг нь хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн оролцоогоороо идэвхтэй хэвээр байдаг насны хэсгийг төлөөлж байна.


- **55-64 насны бүлэг (12.5%):**

- 55-64 насны бүлэгт хамаарах оролцогчид нийт оролцогчдын 12.5%-ийг эзэлж байна.
- Энэ бүлэг нь тэтгэврийн нас руу дөхөж буй хүмүүсийг хамарч байна.

- **65 ба түүнээс дээш насны бүлэг (7.1%):**

- Судалгаанд оролцогчдын хамгийн бага хувийг 65 ба түүнээс дээш насныхан эзэлж байна.
- Энэ нь ахмад настнуудын судалгаанд оролцох идэвх бага байгааг харуулж байна

График 3. Асран хамгаалагчдын насны бүлэг



13-19 насны хүүхдүүдийн асран хамгаалагчдын цахим орчинд хандах давтамжийг доорх графикт харуулав.

- **Өдөр бүр цахим орчинд ханддаг (81.5%):**

- Судалгаанд оролцсон асран хамгаалагчдын дийлэнх буюу 81.5% нь өдөр бүр цахим орчинд ханддаг байна.
- Энэ нь цахим орчинд хандах өндөр идэвхтэй байдал, тэдний өдөр тутмын амьдралд цахим орчны чухал байр суурийг илтгэнэ.

- **Заримдаа (7 хоногт 2-3 удаа) цахим орчинд ханддаг (14.0%):**


- Асран хамгаалагчдын 14.0% нь долоо хоногт 2-3 удаа цахим орчинд ханддаг гэж тэмдэглэжээ.
- Энэ бүлэг нь цахим орчныг тогтмол бус, харьцангуй бага идэвхтэй ашигладаг хүмүүсийг төлөөлж байна.

- **Бараг ашигладаггүй (4.5%):**

- Судалгаанд оролцогчдын хамгийн бага хувь болох 4.5% нь цахим орчинд бараг ханддаггүй гэж тэмдэглэсэн байна.
- Энэ бүлэг нь цахим орчны хэрэглээ маш бага эсвэл огт ашигладаггүйг харуулж байна.

График 4. Асран хамгаалагчдын цахим орчинд хандах давтамж


Асран хамгаалагчдын цахим орчинд хандах давтамж



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бараг тэн хагас буюу 47.4% нь цахим орчинд тогтмол ханддаг бөгөөд энэ нь цахим орчны хэрэглээний өсөлтийг харуулж байна. Цахим орчныг хааяа хэрэглэдэг буюу 33.9%-ийг эзэлж буй бүлэг нь хэрэглээний зохистой менежмент, тэнцвэртэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг шаардаж болох юм. 18.7% нь цахим орчинд ханддаггүй хүүхдүүдийг илэрхийлж байгаа нь зарим орчин, нөхцөлд цахим орчны хүртээмжгүй байдал эсвэл хэрэглээний сонирхол бага байгааг харуулж байна.

График 5. Асран хамгаалагчийн ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх

Асран хамгаалагчийн ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх



Асран хамгаалагчдын ашигладаг платформуудыг доор хувиар харуулав. Бүх платформыг ашигладаг хүн байж болох тул үр дүнг давхардсан тоогоор харуулсан болно.

- **Facebook** нь хамгийн өндөр хэрэглээтэй платформ бөгөөд 78.17%-ийг эзэлж байна.
- **Youtube** нь 59.91%-тай, хоёрдугаарт орж байна.
- **Instagram** нь 51.67%-ийн хэрэглээтэйгээр гуравт орсон байна.
- **Snapchat** болон **Tiktok** нь ижил түвшинд буюу 40.53%-тай байна.
- **Viber** нь 35.86%, **Telegram** нь 36.75%, **Twitter/X** нь 34.30%-тай, харьцангуй бага хэрэглээтэй платформууд болж байна.

График 6. Асран хамгаалагчдын хэрэглэдэг платформ



Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ дараах байдалтай харагдаж байна.

- **Facebook (85.75%):**
 - Хүүхдүүдийн хамгийн их хэрэглэдэг платформ нь Facebook гэж асран хамгаалагчид үзсэн байна.
- **YouTube (82.63%):**
 - Хоёр дахь түгээмэл платформ нь YouTube бөгөөд хүүхдүүд контент үзэх, суралцах, эсвэл зугаацахад ашигладаг.
- **TikTok (72.16%) болон Instagram (71.94%):**
 - Хүүхдүүдийн гурав, дөрөвдүгээрт ашигладаг платформууд нь TikTok болон Instagram бөгөөд богино хэмжээний видео болон зурагт контент хуваалцахад түгээмэл ашиглагддаг.
- **Snapchat (5.57%), Telegram (5.35%), Viber (4.23%), Twitter/X (4.01%):**
 - Эдгээр платформууд харьцангуй бага хэрэглээтэй байна.

График 7. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ

Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ




Судалгаанд оролцсон асран хамгаалагчдын дийлэнх нь буюу 81.96% нь цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контентыг харж байсан гэж хариулсан байна. Энэ нь цахим орчны хяналтгүй хэрэглээ болон насанд тохироогүй контент хүүхдүүдэд хүрэх магадлал өндөр байгааг харуулж байна.

Харин 18.04% нь ийм төрлийн контентыг үзэж байгаагүй гэж хариулжээ. Энэ нь зарим асран хамгаалагчид өөрсдийнхөө болон хүүхдийнхээ цахим хэрэглээг илүү анхааралтай хянадаг байж болохыг илтгэж байна.

График 8. Асран хамгаалагчид цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх

Асран хамгаалагчид цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх



Доорх графикт асран хамгаалагчид цахим орчинд хамгийн их ажиглагдсан насанд хүрэгчдийн контентийн төрлүүдийг харууллаа.

- **Хүчирхийлэл эсвэл график контент (60.1%)**

- Хамгийн өндөр хувийг эзэлсэн нь хүчирхийлэл, график агуулгатай контент юм.
- Энэ төрлийн контент хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул хяналт, зохицуулалт хийх шаардлагатай.

- **Бусад (56.1%)**

- Энд тодорхой бус, бусад төрлийн контентууд багтаж байна. Үүнд олон төрлийн сөрөг контент агуулагдсан байж болно.

- **Маргаантай эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл (51.0%)**

- Төөрөгдүүлсэн болон маргаантай мэдээлэл нь хүүхдийн үнэлэмж, ойлголтод сөргөөр нөлөөлөх боломжтой.

- **Архи, мөрийтэй тоглоомын сурталчилгаа (49.4%)**

- Хүүхдүүдийн хэрэглээний зан төлөвт шууд нөлөөлөхүйц контент тул онцгой анхаарч үзэх шаардлагатай.

- **Садар, зүй бус агуулгатай материал (46.1%)**

- Насанд хүрээгүй хүүхдүүдэд тохиромжгүй агуулга бусад контентийн төрлүүдээс бага хувийг эзэлж байгаа ч, хяналт шаардлагатай.


График 9. Асран хамгаалагчдад их давтамжтай харагдсан насанд хүрэгчдийн контент



Асран хамгаалагчдын дийлэнх нь буюу 79.29% нь хүүхдүүд насанд хүрэгчдийн агуулгатай контентийг санаатай болон санаандгүй байдлаар үздэг гэжээ. Харин 20.71% нь хүүхдүүд санаатай болон санамсаргүй байдлаар насанд хүрэгчдэд зориулсан контент хардаггүй гэж үзэж байна.

График 10. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх

Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх



Доорх графикт асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контент үзсэний улмаас гарч болох сөрөг нөлөөллийг харуулжээ:

- **Сэтгэл санааны болон сэтгэл зүйн дарамт үүсгэнэ (61.5%)**
Хүүхдүүд насанд хүрэгчдийн контент үзэх нь сэтгэл санаа, сэтгэл зүйд хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг гэж асран хамгаалагчид үзжээ.
- **Буруу үйл хэрэгийг хэвийн мэт болгож харагдуулна (53.9%)**
Насанд хүрэгчдийн агуулга нь хүүхдийн үйлдлийн хэв маягийг буруу зүгт чиглүүлэх эрсдэлтэй.
- **Бусад (49.9%)**
Энэ нь тодорхойгүй бусад төрлийн сөрөг нөлөөллийг багтаасан.
- **Эсэн бусын эрсдэлтэй үйлдэлд хүргэнэ (46.3%)**
Насанд хүрэгчдийн контент нь хүүхдийг аюултай, эрсдэлтэй үйлдэл хийхэд хүргэж болзошгүй.
- **Өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлнө (40.3%)**
Ийм төрлийн контент нь хүүхдийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулж, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

- **Ямар нэгэн ноцтой нөлөө байхгүй (35.9%)**

Зарим асран хамгаалагчид хүүхдэд ямар нэгэн ноцтой нөлөө байхгүй гэж үзсэн байна.

График 11. Асран хамгаалагчдын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контент үзсэнээр гарч болох сөрөг нөлөө



- **Хүүхдэд зориулсан контентыг насанд хүрэгчдийн контентоос тусгаарлах (69.93%)**

Асран хамгаалагчдын дийлэнх нь хүүхдэд зориулсан контентыг насанд хүрэгчдийн агуулгаас бүрэн тусгаарлах нь хамгийн үр дүнтэй арга гэж үзжээ.

- **Нийгмийн сүлжээг насны хязгаараар тогтоож хянах (51.00%)**

Нийгмийн сүлжээнд хандах эрхийг насны хязгаарын дагуу хязгаарлах шаардлагатай гэж үзсэн байна.

- **Эцэг эхэд зориулсан контентыг хянах тохиргоо нэвтрүүлэх (46.99%)**

Эцэг эхчүүд өөрсдөө контентыг хянах боломжтой функц эсвэл тохиргоог ашиглахыг санал болгож байна.

- **Хэрэглэгчийн насны илүү нарийвчилсан баталгаажуулах систем нэвтрүүлэх (46.55%)**

Хэрэглэгчийн насыг нарийвчлан шалгах, баталгаажуулах систем хэрэгжүүлэх нь бас чухал гэж үзжээ.

- **Хүүхдийн аюулгүй байдлын талаар мэдээлэл олгох кампанит ажил явуулах (44.32%)**

Хүүхдүүд болон асран хамгаалагчдад аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээлэл өгөх шаардлагатай гэж үзсэн.

- **Хүүхдэд нөлөөлөхүйц сурталчилгаа болон контентыг автоматаар устгах (44.99%)**

Хортой, сөрөг агуулгатай контентыг систем автоматаар устгах нь мөн үр дүнтэй арга зам болно.

- **Насанд хүрэгчдэд зориулсан контентыг илүү хатуу шүүлтүүрээр шүүх (44.99%)**

Насанд хүрэгчдэд тохиромжтой контентыг илүү хатуу, нарийн шүүлтүүр ашиглан хянах нь чухал гэж үзжээ.

График 12. Хүүхдийг насанд хүрэгчдэд зориулсан контентээс хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ


Хүүхдийг насанд хүрэгчдэд зориулсан контентээс хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?



Хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай гэж нийт асран хамгаалагчдийн 89,31% нь үзэж байна. Харин үлдсэн 10,69% нь тийм хууль тогтоомж шаардлагагүй гэж үзсэн байна.

График 13. Хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай гэж та үзэж байгаа эсэх

Хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай гэж та үзэж байгаа эсэх



ХҮҮХЭД

Судалгаанд нийт 405 хүүхэд оролцсон бөгөөд тэдгээр хүүхдүүдийн насны бүлгийг доорх графикт харуулав. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн насны бүлэг харьцангуй тэнцвэртэй байгаа нь судалгааны үр дүнд итгэх итгэлийг нэмэгдүүлж байна.

- **15-17 насны бүлэг (46.34%)**

- Судалгаанд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа насны бүлэг. Энэ нь өсвөр насны хүүхдүүд энэ судалгаанд зонхилж байгааг харуулж байна.

- **13-15 насны бүлэг (31.15%)**


- Дараагийн их хувийг эзэлж байгаа нь бага өсвөр насныхан бөгөөд энэ насныхан чухал бүлэг болохыг харуулж байна.

- **18-19 насны бүлэг (22.51%)**

- Харьцангуй бага хувийг эзэлж байгаа нь насанд хүрэхэд ойртож буй залуус юм.

График 14. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн насны бүлэг

Хүүхдүүдийн насны бүлэг



Доорх графикт хүүхдүүдийн цахим орчинд ханддаг давтамжийг харуулав.

- **Өдөр бүр (85.86%)**

- Судалгаанд оролцогч хүүхдүүдийн дийлэнх олонх нь өдөр бүр цахим орчинд ханддаг байна. Энэ нь орчин үеийн хүүхдүүдийн цахим орчинд ихээхэн хамааралтайг илтгэж байна.

- **Заримдаа (7 хоногт 2-3 удаа) - 9.95%**


- Хоёр дахь түгээмэл давтамж нь ховор хандах бүлэг бөгөөд энэ нь хүүхдүүдийн бага хэсэг цахим орчинд тогтмол бус ордог болохыг харуулж байна.

- **Бараг ашигладаггүй (4.19%)**

- Цахим орчинд ханддаггүй буюу маш бага ашигладаг бүлэг хамгийн бага хувийг эзэлж байна.


График 15. Хүүхдүүдийн цахим орчинд ханддаг давтамж

Хүүхдүүдийн цахим орчинд ханддаг давтамж



Доорх графикт хүүхдүүдийн ашигладаг платформуудыг харуулав. Facebook болон Youtube платформууд хүүхдүүдийн дунд хамгийн өргөн хэрэглэгддэг бол Instagram болон Tiktok платформууд ч мөн өндөр байр суурь эзэлж байна. Энэ нь хүүхдүүдийн сонирхол, үйл ажиллагаа ихэвчлэн нийгмийн сүлжээ, видео контентын платформуудтай холбоотой байгааг харуулж байна.

График 16. Хүүхдүүдийн ашигладаг платформ



Дараах үр дүнгээс харахад хүүхдүүд цахим орчинд ихэвчлэн эерэг, зугаатай контент үзэхийг илүүд үздэг бол хүчирхийлэлтэй болон сөрөг агуулгатай контент бага хувийг эзэлж байгаа ч тэдгээрийн нөлөөг үл тоомсорлож болохгүй. Ингэснээр эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн үзэж буй контентыг анхааралтай хянаж, зөв зохицуулалт хийх нь чухал байна.

График 17. Хүүхдүүдийн цахим орчинд үздэг контентийн төрөл



Доорх графикаас харвал цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент хүүхдүүдэд харагдах нь түгээмэл байна. Энэ нь цахим орчны зохицуулалт, хүүхдүүдийн үзэх агуулгад тавих хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

- **"Тийм" (85.34%)**


- Судалгаанд оролцогчдын ихэнх нь нийгмийн сүлжээн дээр насанд хүрэгчдэд зориулсан контентыг харж байсан гэж хариулжээ. Энэ нь насанд хүрэгчдэд зориулсан агуулга өргөн тархсан, хүүхдүүдэд хүртээмжтэй байгаа гэдгийг харуулж байна.

- **"Үгүй" (14.66%)**

- Судалгаанд оролцогчдын бага хувь нь ийм төрлийн контент харж байгаагүй гэж хариулсан байна.

График 18. Та нийгмийн сүлжээн дээр насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан уу?

Та нийгмийн сүлжээн дээр насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан уу?



Хүүхдүүдийн цахим орчинд харж байсан насанд хүрэгчдийн контентийн төрлийг дараах графикт харууллаа.

- **Хүчирхийлэл эсвэл график контент (59.70%)**

- Насанд хүрэгчдийн контент дотроос хамгийн өндөр хувь эзэлж байгаа нь хүчирхийлэл болон график агуулгатай контент байна. Энэ төрлийн контент нь хүүхдийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй тул хяналт шаардлагатай.

- **Бусад (59.20%)**

- "Бусад" ангилалд багтсан төрөл бүрийн контент ч мөн өндөр хувьтай байна.

- **Садар, зүй бус агуулгатай материал (47.26%)**
 - Зүй бус, насанд хүрэгчдэд зориулсан агуулга хүүхдүүдэд нөлөөлөхүйц өндөр түвшинд байна.
- **Маргаантай эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл (48.51%)**
 - Энэ төрлийн контент нь хүүхдийн бодит байдлын талаарх ойлголтыг төөрөгдүүлэх, буруу мэдээлэлд хөтлөх магадлалтай.
- **Архи, мөрийтэй тоглоомын сурталчилгаа (46.02%)**
 - Хүүхдүүдийн хэрэглээний зан үйлд сөргөөр нөлөөлж болзошгүй контент.

График 19. Хүүхдүүдийн цахим орчинд харж байсан насанд хүрэгчдийн контент



Хүүхдүүдийн ихэнх нь насанд хүрэгчдэд зориулсан контентыг хараад хаахыг илүүд үздэг ч, тодорхой хэсэг нь юу хийхээ мэдэхгүй эсвэл найз нөхөд, эцэг эхээс тусламж хүсэх хандлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн цахим орчинд сөрөг агуулгатай нүүр тулж буй тохиолдолд эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдээс дэмжлэг үзүүлэх, зөв мэдээлэл өгөх шаардлагатай байна.

- **Тэр даруй хаах (62.69%)**
 - Хамгийн өндөр хувийг эзэлж буй үйлдэл нь хүүхдүүд ийм төрлийн контентыг үзмэгц хаахыг илүүд үздэг байна. Энэ нь хүүхдүүд сөрөг агуулгыг ухамсарлан үзэхээс зайлсхийх хандлагатайг харуулж байна.

- **Юу хийхээ мэдэхгүй (58.96%)**
 - Хүүхдүүдийн ихэнх нь ийм контент үзэх үедээ тодорхой арга хэмжээ авахгүй эсвэл юу хийхээ мэддэггүй. Энэ нь хүүхдүүдийн цахим орчинд үзэх контентод чиглүүлэлт, зөвлөгөө дутагдаж байгааг илтгэнэ.
- **Харахгүй байхыг хичээх (48.26%)**
 - Хүүхдүүдийн нэг хэсэг нь сөрөг агуулгаас зайлсхийхийг хичээдэг байна.
- **Найзтайгаа ярих (43.78%)**
 - Зарим хүүхдүүд найз нөхөдтэйгээ ярилцаж, сэтгэл зүйн дэмжлэг авахыг оролддог нь хэн нэгнээс тусламж хүсэх насанд хүрэгчдээс тусламж хүсч чаддаггүйг харуулж байна.
- **Эцэг эхдээ эсвэл том хүнд хэлэх (42.29%)**
 - Хүүхдүүдийн багагүй хувь нь энэ төрлийн асуудлыг эцэг эх эсвэл том хүнд мэдээлдэг. Энэ нь эцэг эхийн дэмжлэг, оролцоо чухал байгааг харуулж байна.

График 20. Хүүхдүүд насанд хүрэгчдэд зориулсан контент хараад хийдэг үйлдэл

Хүүхдүүд насанд хүрэгчдэд зориулсан контент хараад хийдэг үйлдэл



Хүүхдүүд насанд хүрэгчдийн контент хараад тааламжгүй санагддаг ч сонирхолтой санагддаг байна. Тиймээс хүүхдийн үзэж буй контентийн агуулгыг хязгаарлах нь хүүхдийн аюулгүй байдалд чухал нөлөөтэй байна.

- **Тааламжгүй санагддаг (63.93%)**

- Хамгийн өндөр хувийг эзэлж буй нь хүүхдүүд ийм төрлийн контентыг үзсэний дараа тааламжгүй мэдрэмж төрдөг байна. Энэ нь хүүхдүүдийн цахим орчин дахь сөрөг агуулгад эмзэг байгааг харуулж байна.

- **Сонирхолтой санагддаг (58.96%)**

- Судалгаанд оролцогчдын багагүй хувь нь ийм төрлийн контентыг сонирхолтой гэж үздэг байна. Энэ нь насанд хүрэгчдийн контент хүүхдүүдийн анхаарлыг татах боломжтойг илтгэнэ.

- **Хэрэггүй санагддаг (49.50%)**


- Хүүхдүүдийн тал орчим нь насанд хүрэгчдийн контентыг хэрэгцээгүй гэж үздэг бөгөөд энэ нь тэдний агуулгыг хүлээж авах хандлагад эерэг талтайг харуулж байна.

- **Юу ч боддоггүй (6.97%)**

- Хүүхдүүдийн бага хувь нь ийм контентыг үзсэний дараа ямар ч сэтгэгдэл төрдөггүй гэж хариулсан байна.

График 21. Хүүхдүүдэд насанд хүрэгчдийн контент хараад төрдөг сэтгэгдэл


Хүүхдүүдэд насанд хүрэгчдийн контент хараад төрдөг сэтгэгдэл



Доорх графикт хүүхдүүд өөрсдийгөө цахим орчинд аюулгүй байна гэж боддог эсэхийг харууллаа. Үр дүнгээс харахад хүүхдүүдийн дийлэнх нь өөрсдийнхөө цахим орчны аюулгүй байдалд итгэлгүй байгаа бөгөөд тодорхойгүй байр суурьтай байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

График 22. Хүүхэд өөрийгөө цахим орчинд аюулгүй гэж боддог эсэх


Хүүхэд өөрийгөө цахим орчинд аюулгүй гэж боддог эсэх



БАГШ

Энэхүү судалгаанаас харахад багш нарын дунд 45-54 насныхан хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд залуу (25-34 нас) болон дунд насны (35-44 нас) багш нар ижил түвшинд оролцжээ. Ахмад насны багш нарын оролцоо ч мөн чухал хувь эзэлж байна.

График 23. Багш нарын насны бүлэг



Доорх графикт багш нарын цахим орчинд хандах давтамжийг доорх графикт харууллаа. Багш нарын ихэнх нь цахим орчинд өдөр бүр хандаж байгаа нь тэдний ажлын хэрэгцээ болон орчин үеийн технологийн хэрэглээний ач холбогдлыг илэрхийлж байна.

- **Өдөр бүр (92.76%)**
 - Багш нарын дийлэнх нь цахим орчинд өдөр бүр ханддаг байна. Энэ нь багш нарын өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт болон мэдээлэлд цахим орчны хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.
- **Заримдаа (7 хоногт 2-3 удаа) - 4.61%**
 - Багахан хувь нь цахим орчинд тогтмол бус хандаж байна.
- **Бараг ашигладаггүй (2.63%)**
 - Судалгаанд оролцогчдын хамгийн бага хувь нь цахим орчинд хандахгүй байна.

График 24. Багш нарын цахим орчинд хандах давтамж


Багш нарын цахим орчинд хандах давтамж



Хүүхдүүд багш нарынхаа хажууд асран хамгаалагчдынхаа хажууд байдгаас илүү бага давтамжтай цахим орчинд ханддаг байна. Гэсэн хэдий ч цахим орчинд гэрийн даалгавар оруулах, бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл орж байгаагаас үүдэн багш нарын болон хүүхдүүдийн цахим орчны хэрэглээ өндөр байна.


График 25. Багш нарын ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх

Багш нарын ойр орчим дах хүүхдүүд цахим орчинд ханддаг эсэх



Багш нарын дунд Facebook хамгийн өргөн хэрэглэгддэг платформ бөгөөд бусад платформуудтай харьцуулахад илүү давамгайлж байна.

График 26. Багш нарын хэрэглэдэг платформ



Багш нарын бодлоор хүүхдүүд дараах платформыг түлхүү ашигладаг гэж үзжээ.

- **Facebook (98.10%)**

- Багш нарын дийлэнх нь хүүхдүүд Facebook платформыг өргөнөөр ашигладаг гэж үзэж байна. Энэ нь хүүхдүүдийн харилцаа, мэдээлэл солилцоо, социал хэрэглээ Facebook-т төвлөрч байгааг илтгэнэ.

- **Youtube (7.62%)**

- Видео үзэх зорилгоор хүүхдүүд Youtube-г мөн түгээмэл ашигладаг гэж багш нар үзжээ.

- **Instagram (6.67%)**

- Instagram платформыг хүүхдүүдийн багагүй хувь нь ашигладаг гэж багш нар бодож байна.

- **Tiktok (5.71%)**

- Багш нарын үзэж байгаагаар Tiktok платформыг хүүхдүүд хэрэглэдэг боловч харьцангуй бага хувийг эзэлж байна.

- **Telegram болон Twitter/X (тус бүр 1.90%)**

- Хүүхдүүд эдгээр платформуудыг бараг ашигладаггүй гэж үзэж байна.

- **Snapchat (0.95%) болон Viber (0.48%)**

- Эдгээр платформууд хүүхдүүдийн дунд бараг хэрэглэгддэггүй гэж багш нарын дүгнэлт гарчээ.

График 27. Багш нарын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ


Багш нарын бодлоор хүүхдүүдийн хэрэглэдэг платформ



Судалгаанд оролцсон багш нарын талаас илүү хувь нь цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контентыг харж байсан гэж хариулжээ. Энэ нь насанд хүрэгчдэд зориулсан агуулга цахим орчинд өргөн хүрээнд тархсан байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь ийм төрлийн контент харж байгаагүй гэж хариулсан. Энэ нь багш нарын зарим хэсэг цахим орчны ийм төрлийн агуулгатай харьцаж байгаагүйг илтгэнэ.

График 28. Багш нар цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх


Багш нар цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан эсэх



Багш нарын дийлэнх нь хүүхдүүд цахим орчинд насанд хүрэгчдэд зориулсан контент харж байсан гэж үзжээ. Энэ нь багш нар хүүхдүүдийн цахим орчны хэрэглээнд санаа зовниж байгааг харуулж байна. Багш нарын бага хувь нь хүүхдүүд ийм төрлийн контент харж байгаагүй гэж бодож байна. Энэ нь тодорхой хэсэг хүүхдүүдийн цахим орчны хэрэглээ хяналттай байж болохыг илтгэнэ.

График 29. Багш нарын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх


Багш нарын бодлоор хүүхдүүд насанд хүрэгчдийн контентийг хардаг эсэх



Багш нарын талаас илүү хувь нь хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээнд хатуу хууль тогтоомж шаардлагатай гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын багагүй хувь нь хатуу хууль тогтоомж шаардлагагүй гэж үзсэн байна. Энэ нь зарим багш нар хэтэрхий их хяналт нь үр дүнгүй байж болох эсвэл хүүхдийн цахим орчин дахь эрх чөлөөг хязгаарлана гэж үзэж байж болзошгүйг харуулж байна.

График 30. Багш нарын бодлоор хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай юу?

Багш нарын бодлоор хүүхдийг хамгаалах зорилгоор нийгмийн сүлжээг хянах хатуу хууль тогтоомж шаардлагатай юу?



СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

1. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд дараах гол дүгнэлтүүд гарсан:

1.1. ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭ

- Насанд хүрэгчид болон өсвөр насныхны дунд цахим орчны хэрэглээ маш өргөн хүрээнд түгээмэл байгаа нь илт харагдлаа.
- Өсвөр насныхан ихэвчлэн чөлөөт цагаа өнгөрүүлэх зорилгоор цахим орчин ашиглаж байгаа нь тэдний аюулгүй байдлыг хангахад хяналт шаардлагатайг харуулж байна.

1.2. ЦАХИМ ОРЧНЫ ЭРСДЭЛҮҮД

- Хүүхдүүд цахим орчинд сөрөг контентод өртөх, кибер дээрэлхэлтийн хохирогч болох, мэдээллийн аюулгүй байдлаа алдах эрсдэлтэй байгаа нь судалгаагаар батлагдсан.
- Насанд хүрэгчдийн хяналт дутмаг, цахим орчны эрсдэлийн талаар ойлголт муутай байдал нь хүүхдүүдэд сөргөөр нөлөөлж байна.

1.3. НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХАНДЛАГА

- Эцэг эхчүүдийн 60% нь хүүхдийн цахим орчны хэрэглээнд хяналт тавьдаггүй, 25% нь хяналт тавьдаг ч үр дүн муутай байгаа нь хүүхдийн аюулгүй байдлын тулгамдсан асуудал болсныг харуулж байна.
- Насанд хүрэгчдийн хариуцлагагүй хандлага нь хүүхдийн цахим орчны зохисгүй хэрэглээг өдөөж, эрсдэлийг нэмэгдүүлдэг.

1.4. БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭ

- Хүүхдүүдийн цахим орчны аюулгүй байдалд анхаарал хандуулах талаар боловсролын байгууллагууд болон эцэг эхчүүдийн оролцоо дутагдалтай байгаа нь судалгаагаар илэрсэн.

2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүгнэлт дээр тулгуурлан дараах зөвлөмжийг гаргав:

2.1. ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Хүүхдийн цахим орчны хэрэглээнд хяналт тавихын тулд эцэг эхчүүдэд зориулсан сургалтууд зохион байгуулах.
- Хүүхдүүдэд цахим орчны эрсдэлийн талаар зөв мэдээлэл өгөх.
- Аюулгүй байдлыг хангах технологийн арга хэрэгслүүдийг ашиглах, тухайлбал, агуулга шүүгч програм хангамж суулгах.

2.2. БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Цахим аюулгүй байдлын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах.
- Сурагчдад зориулсан цахим орчны зохистой хэрэглээний талаарх семинар, сургалтууд зохион байгуулах.

2.3. ТӨР, ЗАСАГТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох.
- Цахим орчны зохицуулалтыг сайжруулах замаар сөрөг контентын тархалтыг хязгаарлах.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цахим аюулгүй байдлын талаар мэдлэг, мэдээллийг түгээх.

2.4. ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Хүүхдүүдэд цахим орчны эрсдэл, өөрийгөө хамгаалах арга замуудын талаар сургалт, зөвлөгөө өгөх.
- Цахим орчинд танихгүй хүнтэй харилцахгүй байх, хувийн мэдээллээ хамгаалах талаар ойлголт өгөх.

2.5. НИЙГЭМД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

- Цахим орчны зохистой хэрэглээг дэмжих олон нийтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- Хүүхдийн аюулгүй байдалд эцэг эх, багш нар, төр, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах.

Энэхүү зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь хүүхдүүдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг хангаж, эрсдэлийг бууруулахад томоохон хувь нэмэр оруулах юм.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН СУДАЛГААНЫ САНАЛ

1. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь цахим орчин дахь насанд хүрэгчдийн хандлага нь хүүхдийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой байсан бөгөөд дараах үндсэн үр дүнд хүрлээ:

1. **Цахим орчны эрчимтэй хөгжил** нь өсвөр насныханд шинэ боломжуудыг нээж байгаа боловч, аюулгүй байдлын ноцтой асуудлуудыг бий болгож байна.
2. **Насанд хүрэгчдийн хариуцлагагүй хандлага**, цахим орчны зохисгүй хэрэглээ нь хүүхдүүдэд сөрөг нөлөө үзүүлж байна. Эцэг эхчүүдийн хяналт, оролцоо дутмаг байгаа нь хүүхдүүдийг цахим орчны эрсдэлд өртөх гол хүчин зүйл болж байна.
3. **Хүүхдүүдийн цахим орчны мэдлэг, хамгаалалтын түвшин** хангалтгүй байгаа нь тэднийг сөрөг контент, кибер дээрэлхэлт, мэдээллийн аюулгүй байдлын асуудалд өртөх магадлалыг нэмэгдүүлж байна.

Эдгээр үр дүн нь цахим орчны аюулгүй байдлыг хангах чиглэлд яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг илтгэж байна.

2. ЦААШДЫН СУДАЛГААНЫ САНАЛ

Судалгаанд үндэслэн дараах чиглэлээр цаашид гүнзгий судалгаа хийхийг санал болгож байна:

2.1. ЦАХИМ ОРЧНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ

- Цахим орчны зохицуулалт, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судалгаа хийх.
- Сөрөг контентын тархалтыг хязгаарлах төрийн бодлогын үр нөлөөг үнэлэх.

2.2. ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРЫН СУРГАЛТ, ОРОЛЦОО

- Эцэг эхчүүдийн цахим орчны мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалтуудын үр дүнг судлах.

- Сургуулиудын цахим орчны зохистой хэрэглээний сургалтын үр нөлөөг тодорхойлох.

2.3. ХҮҮХДИЙН СЭТГЭЛЗҮЙ БА ЦАХИМ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

- Цахим орчны сөрөг контент хүүхдийн сэтгэлзүйд хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан судлах.
- Кибер дээрэлхэлтээс үүдэлтэй сэтгэлзүйн дарамт, эрсдэлийг бууруулах арга замуудыг тодорхойлох.

2.4. ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛҮҮД

- Хүүхдүүдийн цахим аюулгүй байдлыг хангах технологийн шийдлүүдийг хөгжүүлэх, тэдгээрийн хэрэглээний боломжийг судлах.
- Цахим орчинд аюулгүй байдлыг сайжруулах инновацийн шийдлүүдийг дэмжих судалгаа хийх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ҮСХ. (2024 оны 1 15). *Боловсрол, соёл шинжлэх ухаан*. Үндэсний статистикийн хороо:
https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2002_067V1&CS003_select_all=0&CS003SingleSelect=_1_3_4_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023&viewtype=table-ээс Гаргасан

ҮСХ. (2024 оны 3 13). *Хүн ам*. Үндэсний статистикийн хороо:
https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_4_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023&viewtype=table-ээс Гаргасан

ҮСХ. (2024 оны 3 13). *Хүн ам*. Үндэсний статистикийн хороо:
https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_6_7_8_9_10_11_12_13_14_15_16&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023&viewtype=table-ээс Гаргасан